Татварын талаарх илэн далангүй яриа

# ”ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ХАОАТ)”

| | |
|---|---|
| **ХАОАТ гэж юу вэ?** | ХАОАТ нь татвар төлөгчийн дараах орлогуудад ногдоно. Үүнд: цалин хөлс, аж ахуйн үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хувиараа материал бэлтгэж борлуулсны орлого, тэмцээн уралдааны шагналын орлого, малчин өрхийн орлого, тоглоом болон хонжворт сугалааны орлого болон бусад орлогууд орно. |
| **ХАОАТ-ыг хэн төлөх вэ?** | Монгол улсын иргэн гадаадын харъяат иргэд нь ХАОАТ төлөгч мөн. |
| **Татварын хувь хэмжээ ямар байдаг вэ?** | **Татвар ногдуулах сарын орлого : (төгрөг)** — **Хувь:**<br>0 – 200,000 — **10%**<br>200,000 – 400,000 — **20%**<br>400,000 + — **30%**<br>Тайлбар:<br>Татварын хувь тус бүр нь таны орлогын хэмжээнээс хамааралтай. Сарын орлогын эхний 200.000 төгрөгийн орлогод 10%ын татвар ногдож, дараагийн 200.000 төгрөгийн орлогод 20%, 400.001 төгрөгөөс дээш орлогод 30%-ын татвар ногдоно. |
| **ХАОА Татварын ”хөнгөлөлт”** | Татвар төлөгчийн ногдсон нийт татвараас сард 4000 төгрөгийг чөлөөлнө. |
| **ХАОАТ нь төсвийн орлогын хичнээн хувийг эзэлж байна вэ?** | <br><br>Төсвийн орлогод ХАОАТ **7%**-ыг эзэлж байна.<br><br><u>Татвар төлөгчийн тоо:</u><br>2003: 223,027<br>2004: 260,174 |

**Жишээ:**

**Сарын 240,000 төгрөгийн орлогод ногдуулах татварын тооцоо**

| | | Төгрөг | Та өөрийнхөө татварыг энд тооцож үзнэ үү: |
|---|---|---|---|
| Сарын нийт орлого | | 240,000 | |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 10% | 24,000 | |
| ХАОАТ ногдуулах орлого: | | 216,000 | |
| Хувь хэмжээ: | | | |
| 10%-д албан татварын ногдох орлогын хэмжээ | 10% | 200,000 | |
| 20%-д албан татварын ногдох орлогын хэмжээ | 20% | 16,000 | |
| 30%-д албан татварын ногдох орлогын хэмжээ | 30% | 0 | |
| Нийт төлөх татвар | | 23,200 | |
| Татварын хөнгөлөлтийн хэмжээ: | | -4,000 | -4000 |
| Цэвэр төлөх татвар: | | 19,200 | |
| НДШ, ХАОАТ-ыг төлсний дараах орлого (Таны гар дээр очих орлогын хэмжээ) | | 196,800 | |

Тайлбар:
Татварын шатлал тус бүрт өөр өөр хувь хэмжээ тооцогдоно. Дээрх жишээгээр эхний 200,000 төгрөгт 10%, үлдэх 16,000 төгрөгт 20%-ын татвар ногдож байна.
Нийт ногдсон татварын хэмжээ 23,200, цэвэр төлөх татварын хэмжээ 19,200 төгрөг байна.

---

Энэхүү мэдээлэл нь татварын шинэтгэлийн асуудлаар нийт ард иргэдийн санаа бодлыг сонсох зорилгоор Сангийн яам, ҮТЕГ-аас явуулах ” Татварын талаарх илэн далангүй яриа” цуврал хэлэлцүүлгийн хоёр дугаарх юм. Та бүхэн Татварын шинэчлэлийн хуулийн төслийн англи, монгол хувилбарыг " Нээлттэй засаг" вэб сайт (www.open-government.mn), Сангийн Яамны вэб сайт (www.mof.pmis.gov.mn), ҮТЕГ-ын (www.mta.mn) сайтаас үзэж, саналаа ирүүлж болно.